



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/324

Мөрөн сум

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн
тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, 70.1.2, 70.1.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах (зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар болон санал авах байранд), хяналтын тооллого хийхтэй холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт 2024 оны 06 дугаар сарын 27, 28, 29-ний өдрийг дуустал хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг, 06 дугаар сарын 28-ны өдөр соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллуулахыг тус тус хориглосугай.


2. Тус өдрүүдэд дээрх төрлийн үйл ажиллагаа явуулахгүй байхыг төрийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (дэд хурандаа, Д.Мөнхжаргал), Хүнс хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр), аймгийн Биеийн тамир, спортын газар (Б.Баярсайхан), аймгийн Соёл, урлагийн газар (Л.Батцэцэг), сумын Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийг олон нийтэд сурталчилж, мэдээлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР



Захирамж2024

6712011015